



## БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 21 өдөр

Дугаар A/04

Улаанбаатар хот

Г “Байгууллагын дэргэдэх Залуучуудын зөвлөл”-ийн байгуулан, бүрэлдэхүүнийг батлах тухай

Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.7.1, “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь, заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Байгууллагын дэргэдэх Залуучуудын зөвлөл”-ийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга  
Гишүүн  
Гишүүн

Нарийн бичиг

Дарга  
Агрономч  
Механик

Хүний нөөц, бичиг  
хэргийн мэргэжилтэн

- “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын “Байгууллагын дэргэдэх Залуучуудын зөвлөл”-ийн ажиллах дүрмийг Хөдөлмөр, нийгэм хамгааллын Сайдын 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А/72 дугаар тушаалаар баталсан “Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай” тушаалыг баримталж ажилсугай.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төслийн менежер /Г.Пүрэвсүрэн/-д даалгасугай.

ДАРГА

Г.ГАЛДӨЛ



3140600246

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ  
ОНӨТҮГ-Н ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 05 дугаар сарын 20

№ 01

Улаанбаатар хот

Хурал эхэлсэн хугацаа 11:05 минут

Хурлыг удирдсан: Дарга Г.ГАЛДӨЛ

Хуралд оролцсон: Менежер Г.Пүрэвсүрэн, нягтлан бодогч Ц.Мөнхдөл, агрономч Б.Баярцэцэг, Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн А.Гэрэлтуяа

**Хэлэлцэх асуудал:**

1. Байгууллагын дэргэдэх Залуучуудын зөвлөл байгуулах тухай

**Сонссон нь:**

**Дарга Г.Галдөл:** 2021 оны 05 дугаар сарын 18 нд Нийслэлийн засаг даргын тамгын газраас 02-02/1950 дугаартай албан бичгээр байгууллагын дэргэд Залуучуудын зөвлөл байгуулан ажиллах тухай албан бичиг ирүүлсэн байна. Иймд албан хаагчдын саналыг сонсоё.

**Менежер Г.Пүрэвсүрэн:** Манай байгууллага 10 хүний орон тоотой тийм болохоор залуучуудын зөвлөл гэхээр байгууллагын залуу албан хаагчдыг томилох саналтай байна. Зөвлөлийн даргаар Байгууллагын дарга Г.Галдөл өөрөө байвал зохимжтой байх Нарийн бичгээр Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн Гэрэлтуяаг тавих саналтай байна.

**Нягтлан Ц.Мөнхдөл:** Саналыг дэмжиж байна. Гишүүнээр Агрономч Баярцэцэг, Механик М.Бат-Эрдэнэ, нарыг томилох саналтай байна.

**Агрономч Б.Баярцэцэг:** Манай байгууллагад Зөвлөлийн ажиллах дүрэм журмыг шинээр гаргаж баталж өгөх хуулийн мэргэжилтэн байхгүй учир Залуучуудын зөвлөлийн ажиллах дүрмийг Хөдөлмөр, Нийгэм хамгааллын сайдын баталсан A/72 дугаар тушаалыг баримталж ажиллах саналтай байна.

**Шийдвэрлэсэн нь:**

1. Байгууллагын дэргэдэх Залуучуудын Зөвлөлийг байгуулан Зөвлөлийн даргаар Байгууллагын дарга Г.Галдөл, Гишүүнээр Агрономч Б.Баярцэцэг, Механик Бат-Эрдэнэ зөвлөлийн нарийн бичгээр Хүний нөөц бичиг хэргийн мэргэжилтэн А.Гэрэлтуяа нарыг сонгохоор болов.

Хурал 12:25 минутад дуусав.

Танилцсан:

Дарга

Хурлын тэмдэглэл хөтөлсөн :

Хүний нөөц бичиг хэргийн мэргэжилтэн

Г.ГАЛДӨЛ

А.ГЭРЭЛТУЯА